



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 338


Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт, “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.24 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Бат капитал менежмент ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд Эрдэнэ-Очир овогтой Баярмандалыг томилохыг зөвшөөрсүгэй.
2. Гүйцэтгэх захирлыг өөрчлөн томилсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Бат капитал менежмент ҮЦК” ХХК /Э.Баярмандал/-д үүрэг болгосугай.
 - 1/ Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийлгэж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх;
 - 2/ Хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллах;
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН